






АНГИОГРАФИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Хувилбарын дугаар: 01

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-11-01

Баримт бичгийн дугаар

Баримт бичгийг хариуцах нэгж			
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:		Ангиографийн их эмч Д.Мөнхнасан Б.Амбасалмаа	
Санал өгсөн:	ЭЗДЗахирал	Д.Болормаа	
Хянаж батласан:		БОЭТ-ийн захирал	



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана)
1			Баримт бичгийн анхны хувилбар
2			
3			

АГУУЛГА

- 1. ЗОРИЛГО**
- 2. ХАМРАХ ХҮРЭЭ :**
- 3. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ**
- 4. ХОЛБОГДОЛТОЙ БУЮУ ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ**
- 5. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)**
- 6. АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**
- 7. АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 8. АНГИОГРАФИЙН ШИНЖИЛГЭЭНД ӨВЧТӨН БЭЛТГЭХ**
- 9. АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН АЖИЛЧДЫН ҮҮРЭГ**
- 10. АНГИОГРАФИ ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**
- 11. АМИЛУУЛАХ, ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ / CODE BLUE БАГ ИДЭВХИЖҮҮЛЭХ/**
- 12. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ТОНОГ ТОНОГ ТӨХӨӨРМЖИЙН ЖАГСААЛТ**
- 13. ХАРИУЦЛАГА**

1. ЗОРИЛГО

1.1 Эмчлүүлэгчдэд аюулгүй чанартай ангиографийн оношилгоо эмчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх

1.2 Ангиографийн оношилгоо эмчилгээг үзүүлэгч эмч эмнэлгийн мэргэжилтний харилцааг зохицуулах, үүрэг хариуцлага, сахилга дэг журам, тасаг нэгжийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 БОЭТөвийн нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн, ангиографийн хэсгийн эмч мэргэжилтэн дагаж мөрдөнө.

3. НЭР ТОМЬЁО ТОВЧИЛСОН ҮГ

- АД- Артерын даралт
- АГ-Артерын гипертензи
- АРХ- Ангиотензин рецепторын хориглогч
- АХФС-Ангиотензин хувиргагч ферментийн саатуулагч
- БМГ-Бага молекулт гепарин
- БНЛП- бага нягтралттай липопротейн
- БХ-Бета хориглогч
- БТС-Баруун титэм судас
- БУЭ-Бүлэн уусгах эмчилгээ
- ГБХХ-Гисийн баруун хөлийн хориг
- ГЗХХ-Гисийн зүүн хөлийн хориг
- ДД-Диастолын даралт
- ЗД-Зүрхний дутагдал
- ЗТС-Зүүн титэм судас
- ЗТСБ-Зүүн титэм судасны багана
- ЗХАШ-зүрхний хэт авиан шинжилгээ
- ЗХД- Зүүн ховдлын дутагдал
- ЗЦБ-зүрхний цахилгаан бичлэг
- ЗЦТ-Зүрхний цохилтын тоо
- ЗЦД-Зүрхний цочмог дутагдал
- ЗШ-Зүрхний шигдээс
- КТ-Компьютер томографи
- КФК-МВ- креатинфосфозкиназа-мв фракц
- ЛДГ-Лактатдегидрогеназа
- ммМУБ- миллометр мөнгөн усны багана
- СД-Систолын даралт
- ТиСДО-титэм судсан дотуурх оношилгоо
- ТиСДЭ- титэм судсан дотуурх эмчилгээ
- ТиСМЗ- титэм судсан дотуурх мэс засал
- ТМГ-том молекулт гепарин
- ТС- Титэм судас
- ТСБЗШ-титэм судасны бөглөрөөгүй зүрхний шигдээс
- ХХУС-ховдол хоорондын уруудах салаа /зүүн титэм судасны/
- ХАС-Ховдлын арын салаа

1	Ангиографийн оношилгоо эмчилгээний заалт гаргах				RA	RAI	RAC	I
2	Холбогдох шинжилгээ оношилгоог бүрдүүлэх				RA	RAC	RAC	I
3	Эмчлүүлэгчийн заагдсан эмчилгээг хийх		RAC	I	AI		I	
4	Зөвлөх эмч болон нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийх				RAC	RAC	CI	CI
5	Төлөвлөгөө гаргаж батлуулах	I	I	I	I	I	RAC	I
6	Өвчтний ар гэрийхэнд уулзах , мэдээлэл өгөх, зөвшөөрөл авах				RAC		RAC	I
7	Ангиографийн оношилгоо эмчилгээнд үйлчлүүлэгчийг бэлтгэх	CI	RAC	CI	CI		I	
8	Ангиографийн оношилгоо эмчилгээний бэлтгэл хангах, бэлэн байдлыг бүрдүүлэх	RAC	C	RAC	CI		ACI	CI
9	ЭТҮХХалдвар хамгаалал дэглэм баримтлан шаардлагатай ажилбар хийх /ТВГ, уян зүү тавих, зонд, тавих, зохиомол амьсгалын аппарат авах/	CI	RAC	CI	RAC	CI	CI	I
10	Ангиографийн оношилгоо эмчилгээ хийгдэх	RAC		RAC	I	I	RAC	I

1 1	Амилуулах, лавшруулсан тусламж үзүүлэх / CODE BLUE баг идэвхижүүлэх/	С	С	С	RAC	RAC	RAC	I
1 2	Өвчний түүхэнд тэмдэглэл баримтжуулалт хийх				RAC		RAC	I
1 3	Үйлчлүүлэгчийг тасагт шилжүүлэх, хянах, гаргах		RAC		RAC	CI	CI	CI
1 4	Ангиографийн оношилгоо эмчилгээний үр дүнг өвчтөн болон ар гэрт танилцуулах				CI	I	RAC	I
1 5	III –р шатны холбогдох эмч нараас эмчилгээ оношилгооны зөвөлгөө авах / тээвэрлэлт/				RAC	CI	CI	RAC

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

7. АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

7.1 Ангиографийн хэсэг нь рентген ангиографийн аппарат болон шаардалагатай бусад аппарат эмнэлгийн хэрэгсэлээр бүрэн хангагдсан, зориулалтын өрөөнд үйл ажиллагаа явуулна.

7.2 Ангиографийн шинжилгээ болон ажилбарыг амбулаторийн үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчдэд болон яаралтай журмаар бүх насны хүмүүст эмчийн захиалгын дагуу хийнэ.

7.3 Ангиографийн эмчийн төлөвлөгөөний дагуу оношилгоо, эмчилгээний ажилбарууд хийнэ.

7.4 Тээвэрлэх боломжгүй тохиолдолд өвчтөнд мэс заслын явцад хагалгааны өрөөнд болон тасагт дүрсийн хяналттай зарим ажилбарыг хийх ба бусад тохиолдолд Ангиографийн тасагт тээвэрлэн оношилгоо, эмчилгээний ажилбар хийнэ.

7.5 Ангиографийн тасагт рентген ангиографи (Siemens artis zee monoplane) ашиглан оношлогоо, эмчилгээ хийнэ.

7.6 Радиологийн тасагт КТГ ба ЭХО хяналттай цээж, хэвлийн болон ясны эд эсийн шинжилгээ хийнэ.

Ангиографийн төхөөрөмжийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан тохиолдолд гэрээнд заагдсан эмнэлгүүд рүү өвчтнийг тээвэрлэн оношилгоо, эмчилгээ хийгдэх ба дүрс оношилгооны тасгийн бусад эмнэлгүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу зохицуулагдана.

8. АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1 Ангиографийн хэсгийн эмч, технологч, сувилагч нар тогтоосон хуваарийн

дагуу ажиллах ба шаардлагатай тохиолдолд илүү цагаар, амралтын өдөр тогтоосон хуваарийн дагуу дуудлагаар ажиллана.

8.2 Ангиографийн тасаг нь Монгол улсын хөдөлмөрийн хортой нөхцлийн ажил мэргэжлийн журмын дагуу богиносгосон цагаар ажиллана.

8.3 Хийгдэх мэс ажилбарын дараалал хүснэгт №1т хавсаргав.

Хүснэгт № 1

Ангиографийн шинжилгээний дараалал	Хийгдэх ажил
Ерөнхий бэлтгэл	<ul style="list-style-type: none"> • Өрөөний цэвэрлэгээг үнэлэх • Тоног төхөөрөмжийн хэвийн болон аюулгүй ажиллагааг шалгах • Шинжилгээний төрөл ба цаг авалтыг шалгах • Тухайн өдрийн шинжилгээнд хэрэглэгдэх эмнэлгийн өндөр өртөгт болбон бусад хэрэгсэл бэлдэх • Яаралтай тусламжийн эм, хэрэгслийг шалгах • Хамгаалалтын хувцсын бүрэн бүтэн байдлыг шалгах
Нарийвчилсан бэлтгэл	<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчийг хүлээн авах • Үйлчлүүлэгчийг таних • Нөхөн үржихүйн насны эмэгтэй үйлчлүүлэгчээс жирэмснийг илрүүлэх асуумж авах • Бага насны хүүхэд бол эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас рентген шинжилгээний зөвшөөрөл авна. • Өөр эмнэлэгт хийгдсэн харьцуулах лабораторын болон дүрс оношилгооны шинжилгээнүүдийг авна <ul style="list-style-type: none"> • Мэс ажилбарт орохын өмнө дараахь шинжилгээнүүдийг бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> ○ ЦЕШ ○ ШЕШ ○ Биохими <ul style="list-style-type: none"> ▪ Бөөрний үйл ажиллагаа ▪ Элэгний үйл ажиллагаа ▪ Сахар ○ ХДХВ, HCV, HBV, RPR ○ Коагулограмм ○ Зүрхний цахилгаан бичлэг ○ Цуллаг эрхтний хэт авиан шинжилгээ ○ Цээжний рентген ○ Заалтаар хийгдэх \Зүрхний эхо, Толгойн КТГ, MRI, Дофлер, Дуплекс\ • Үйлчлүүлэгчид гарч болох эрсдлийг бүрэн тайлбарлаж зөвшөөрөл авах • Зөвшөөрлийн хуудас бөглүүлэх • Үйлчлүүлэгчийн хувцас солиулах, ээмэг бөгж зэргийг тайлуулах, мэс заслын нэг удаагийн маск болон малгай өмсгөх
Шинжилгээний ерөө	<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчийн шинжилгээний өрөөнд оруулна.

	<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчид шинжилгээний талаар зохих тайлбар өгнө, тайвшруулна • Үйлчлүүлэгчийг зөв байрлуулна • Үйлчлүүлэгчийг хяналтын самбартай холбоно, тухтай байдлыг лавлан асууна • Тайвшруулга хийсэн тохиолдолд бүртгэл хөтлөнө • Хатгалт хийх талбайд ариутгал хийнэ • Эмч төлөвлөгөө захиалгын дагуу шинжилгээг хийнэ • Шинжилгээний дараа анхаарах зүйлс, дэглэмийг тайлбарлана • Үйлчлүүлэгчийг хяналтын хэсэгт шилжүүлнэ. • Өрөөнд цэвэрлэгээ хийнэ. • Тоног төхөөрөмжийг дараагийн үйлчлүүлэгчийг хүлээн авахад бэлтгэнэ • Зургийн боловсруулалт хийж, рентген туяаны тунг тооцож бүртгэлд хөтөлнө. • Эмч шинжилгээний дүгнэлт болон ажилбарын тэмдэглэл бичнэ.
Хяналтын өрөө	<ul style="list-style-type: none"> • Тайвшруулагатай шинжилгээ, ажилбарын дараа үйлчлүүлэгчийн хяналтын өрөө эсвэл тасагт оруулна • Үйлчлүүлэгчийг хяналтын самбартай холбоно, биеийн байдлыг лавлан асууна • Судсанг тавигдсан дамжуулагч гуурсыг авч 20-30 минут даралт хийж, даралттай боолт хийнэ • Үйлчлүүлэгчийг тасгийн сувилагчид хүлээлгэж өгнө. • Амбулаторын үйлчлүүлэгч бол судсан дотуур тавигдсан гуурсыг авч үйлчлүүлэгчийг үдэж гаргана • Өрөө, тоног төхөөрөмжийг дараагийн үйлчлүүлэгчийг хүлээн авахад бэлтгэнэ

9. АНГИОГРАФИЙН ШИНЖИЛГЭЭНД ӨВЧТӨН БЭЛТГЭХ

А. Эмчийн хариуцан хийх бэлтгэл ажил ба үүрэг

- Ангиографийн шинжилгээний өмнө хийгдсэн байх ёстой шинжилгээг бүрдүүлэх.
- Эмч нарын хамтарсан үзлэгт танилцуулж, шинжилгээний заалт гарган түүхэнд бичих.
- Бага насны хүүхдийг унтуулгын эмчид үзүүлж шинжилгээнд бэлтгэх.
- Шинжлүүлэгчид болон асран хамгаалагчдад шинжилгээний талаар танилцуулах.

Б. Сувилагчийн хариуцан хийх ажил ба үүрэг

- Шинжлүүлэгчийн өндөр , биеийн жинг үзэж түүхэнд тэмдэглэж ариун цэврийн бэлтгэл хангах.
- Шинжлүүлэгчийг төлөвлөгөт бол тайван амрааж өглөө цусны даралт, судасны цохилт, халууныг үзэж түүхэнд тэмдэглэх.
- Тодосгогч бодисын сорилыг шинжилгээнээс 2 цагийн өмнө үзэж үр дүнг өвчтөний түүхэнд бичиж тэмдэглэх.

- Өвчин намдаагч болон заагдсан эмийг шинжилгээнээс 30 минутын өмнө өгөх.
- Өглөө өлөн байлгаж, шинжлүүлэгчийн хиймл шүд, цаг, бөгж, зэмэг зүүлтийг авахуулах.
- Шинжлүүлэгчийг хэвтрийн дэглэмд зөөвөрлөх.
- Шинжилгээний дараа цавьны судсаар орсон тохиолдолд 24 цаг хэвтрийн дэглэмд байлгах.
 - Хэсэг газрын боолтон дээр 30 Минут хүйтэн жин тавьж хянах

10.АНГИОГРАФИЙН ХЭСГИЙН АЖИЛЧДЫН ҮҮРЭГ

10.1 Ажилтнуудын нийтлэг үүрэг

1. Халдвар хамгааллын дүрмийг баримтлана.
2. Эм эмнэлгийн хэрэгслийг зааврын дагуу ашиглана.
3. Ангиографийн аппарат болон бусад тоног төхөөрөмжийн гарын авлага, аюулгүй ажиллагааны журамтэй танилцсан байна.
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглах заавар зөвлөмжтэй танилцана.
5. Рентген туяаны аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.
6. Тогтмол мэдлэг, мэргэжлийн ур чадвараа сайжруулна.
7. Холбогдох бичиг баримтын хөтлөлт хийнэ.
8. Үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэлийг хадгална, үйлчлүүлэгчидтэй ёс зүйтэй харилцана.
9. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангана.
- 10.Эмнэлгийн бусад тасгийн ажилтнуудтай үр дүнтэй хамтран ажиллана.
- 11.Тоног төхөөрөмж, эм, хэрэгслийг үр дүнтэй ашиглана.
- 12.Тасгийн ба байгууллагын ажилд идэвхи, санаачлагатай оролцоно.

10.2 Ангиографийн эмчийн үүрэг

1. Ангиографийн үйл ажиллагааны ерөнхий менежмент хийнэ.
2. Ангиографийн шинжилгээний чанар, аюулгүй ажиллагааг хангахад оролцоно.
3. Ангиографийн шинэ журам гаргах, шинэчлэхэд оролцоно, хэрэгжилтэнд хяналт тавина.
4. Ангиографийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, хүний нөөцийг үр дүнтэй ажиллуулахад оролцоно.
5. Ангиографийн жилийн төлөвлөгөө гарган шууд удирдлагад танилцуулна (OGSM).
6. Хэсгийн ажилтнуудын жилийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн хувь хүн бүрт танилцуулна.
7. Хэсгийн ажилтнуудын мэргэжлийн гадаад, дотоод сургалтын төлөвлөгөө гарган, биелэлтийг хянана.
8. Ангиографийн хэсгийн хүний нөөцийн хөгжил, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, засвар үйлчилгээний талаар холбогдох хүмүүст санал гаргана.
9. Сар бүр ангиографийн эмч нарын ажлын цагийн тооцоог гарган санхүүгийн албанд хүргүүлнэ.
- 10.Хуваарийн дагуу, мэргэшлээс хамааран эмчилгээ, оношилгооны ажилбаруудыг хийнэ.
- 11.Мэргэшлээс хамааран тасагт болон амбулаторын үйлчлүүлэгчид үзлэг зөвлөгөө өгнө.
 Үйлчлүүлэгчид ба тэдгээрийн гэр бүл, хууль ёсны асран хамгаалагчид эмчилгээ, оношилгооны хүртээл үр дүн, давуу тал болон ажилбартай холбоотой эрсдэл хүндрэлийн талаар мэдээлэл өгнө.

12. Бусад тасгийн эмч, мэргэжилтнүүдтэй үр дүнтэй хамтарч ажиллана.
13. Шинэ, залуу мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулахад оролцоно.
14. Технологч, сувилагч нарыг мэргэжлийн удирдлагаар хангахад оролцоно.
15. Ажилбар эхлэхээс өмнө үйлчлүүлэгчийн зөвшөөрлийн хуудсыг үнэн зөв бөглүүлнэ.

10.3 Техникчийн үүрэг

1. Үйлчлүүлэгчийг шинжилгээнд бэлтгэхэд хамтран оролцоно, зохих мэдээлэл өгнө.
2. Шинжилгээнд хэрэглэгдэх эм хэрэгсэл, аппаратыг зохих журмын дагуу бэлтгэнэ.
3. Ангиографийн аппарат ба бусад тоног төхөөрөмжийг ашиглаж зөвлөмж, стандартын дагуу шинжилгээг хийнэ.
4. Ангиографийн оношилгоо эмчилгээнд хэрэглэх эмнэлгийн хэрэгслийг зориулалтын дагуу үр дүнтэй ашиглахад эмчид тусална.
5. Шинжилгээний үед үйлчлүүлэгч ба багын бусад гишүүдийг зөв чиглүүлэнэ, хянана.
6. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллана, журмын дагуу шинжилгээний болон хяналтын өрөө рүү тээвэрлэнэ.
7. Ангиографийн шинжилгээг захиалгын дагуу, чанартай хийж гүйцэтгэнэ, зураг боловсруулж, шаардлагатай бол зураг болон CD хэвлэнэ.
8. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгалыг ханган ажиллана.
9. Аппарат, тоног төхөөрөмж ба хар тугалган хормогчийг тогтмол шалгах чанарын хяналт хийнэ. Хамгаалалтын хувцасны бүрэн бүтэн байдлыг хангах.
10. Ангиографийн хэсгийн болон эмнэлгийн мэргэжилтний хязгаарлалтын журмыг мөрдүүлнэ.
11. Ангиографийн хэсгийн үйлчилгээний чанар, аюулгүй ажиллагаа, оношилгоо эмчилгээний хэвийн үр дүнтэй явагдах нөхцөл хангаж, чанарын мэдээг хугацаанд нь өгнө.

10.4 Сувилагчийн үүрэг

1. Үйлчлүүлэгчийг оношилгоо, эмчилгээнд бэлтгэхэд хамтран оролцоно, зохих мэдээлэл өгнө.
2. Тодосгогчийн сорил тавьж, ажилбарын өмнө судсанд уян гуурс тавина.
3. Эм, хэрэгслийн хадгалалт, ариутгал, ашиглалт, орлого зарлагыг хариуцана.
4. Ажилбарын өмнө ба дараах time-out-ыг удирдана.
5. Эмчилгээ, оношилгооны ажилбарын өмнө, явцад мөн дараа үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянана.
6. Ажилбарын эмчийн заавраар эмчилгээ хийнэ.
7. Тайвшруулагатай шинжилгээний дараах хяналт хийнэ.
8. Ажилбарын өмнө болон дараах халдвар хамгаалал болон цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах

10.5 Үйлчлэгчийн үүрэг.

1. Ажилбарын явцад болон дараах өрөөний цэвэрлэгээг хариуцна.
2. Халдвартай хог хаягдалыг журмын даргуу зөөвөрлөх ба тусхай хогийн цэгт хүргэнэ.

11. АНГИОГРАФИ ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

1	Титэм судасны оношилгооны ангиографи	Coronary diagnostic angiography
2	Титэм судасны нарийслыг тэлэх эмчилгээ	Coronary angioplasty
3	Тархины судасны оношилгооны ангиографи	Cerebral diagnostic neuro angiography
4	Гүрээний судасны оношилгооны ангиографи	Carotid diagnostic angiography
5	Гүрээний судасны нарийслыг тэлэх эмчилгээ	Carotid angioplasty
6	Мөчдийн судасны оношилгооны ангиографи	Peripheral vascular angioplasty
7	Мөчдийн судасны нарийслийг тэлэх эмчилгээ	Peripheral vascular diagnostic angiography
8	Зүрхний хэм тохируулагч тавих эмчилгээ	Pacemaker placement
9	Бөөрний артерийн судасны нарийсал шалгах оношилгооны ангиографи	Renal artery diagnostic angiography
10	Төвийн венд гемодиализын гуурс байрлуулах	Tunnel catheter placement
11	Төвийн венд хими эмчилгээний гуурс байрлуулах	Chemotherapy port placement
12	Хэлийн ба цээжний хөндийн шингэнд урасгуур гуурс байрлуулах	Percutaneous chest&abdominal drainage (PAD)
13	Цөсний замын холангиографийн шинжилгээ	Percutaneous transhepatic cholangiography (PTC)
14	Хэвлийн ба цээжний хөндийн эрхтэний буглаанд гуурс байрлуулах	Percutaneous chest& abdominal abscess drainage (AD)
15	Радио долгионоор цуллаг эрхтнүүдийн хавдрыг түлэх эмчилгээ	Radiofrequency Ablation (RFA)
16	Цөсний замд урсгуур гуурс байрлуулах	Percutaneous transhepatic biliary drainage (PTBD)
	Элэгний хавдрын тэжээгч судсыг бөглөх эмчилгээ	Transarterial Chemoembolization (TACE)
17	Үүдэн венийг бөглөх эмчилгээ	Portal venous embolization

18	Умайн артери бөглөх эмчилгээ	Uterine artery (fibroid)embolization (UAE)
19	Төвийн болон мөчдийн венийн судасны оношилгооны венографи	Central and extremity diagnostic venography
20	Захын судасны эмгэг сүлжээрийн склероз эмчилгээ.	Peripheral malformation sclerotherapy
21	Төвийн болон мөчдийн венийн судасны нарийслыг тэлэх эмчилгээ	Central and extremity venoplasty
22	Доод хөндийн венд филтер тавих	Vena cava filter (VCF)
23	Өндгөвчний өргөссөн венийн судсыг бөглөх эмчилгээ	Ovarian vein embolization (OVE)
24	Варикоцелийг бөглөх эмчилгээ	Varicocele embolization (VE)
25	Бөөрөнд гуурс тавих	Percutaneous nephrostomy
26	Бөөрний артерийн судсыг бөглөх эмчилгээ	Renal artery embolization (RAE)
28	Гүрээний венээр дамжуулан элэгнээс эд авах шинжилгээ	Transjugular liver biopsy (TJLB)
29	Ходоодны өргөссөн венийн судсыг баллон ашиглан бөглөх эмчилгээ	Ballon-Occluded Retrograde Transvenous Obliteration of Gastric Varices (BRTO)
30	Гүрээний венээр дамжуулан элэгний венийг үүдэн вентэй холбох эмчилгээ	Transjugular Intrahepatic Portosystemic Shunt (TIPS)
31	Нурууны өвдөлт намдаах болон бусад ажилбарууд	Spinal interventional procedures
32	Бронхийн артерийг бөглөх эмчилгээ	Bronchial artery embolization
33	Түрүү булчирхайн хоргүй хавдрын үед түрүү булчирхайн артерийг бөглөх эмчилгээ	Prostatic artery embolization
	Total procedures	

12.АМИЛУУЛАХ, ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ / CODE BLUE БАГ ИДЭВХИЖҮҮЛЭХ/

“CODE BLUE” журмаар зохицуулагдана.

**13. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ТОНОГ
ТОНОГ ТӨХӨӨРМЖИЙН ЖАГСААЛТ / ХАВСРАЛТ -6/**

13.1 эмс-ын 2009 оны 388 тоот тушаал, 2019 оны а/293 тоот тушаалын дагуу боэт-ийн яаралтай тусламжийн үйлчилгээнд хэрэглэгдэх эм, тариа, нэг удаагийн хэрэгслийн жагсаалт

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Доод хэмжээ
1.Эпилепсийн эсрэг хэрэглэх бэлдмэл				
1	Карбамазепин	200мг	шах	10
2.Ерөнхий мэдээгүйжүүлэг бэлдмэл				
1	Тиофентал натри	0.5г-1г	фл	5
3. Булчин сулруулах, холинэстразийн эсраг бэлдмэл				
1	Тракриум	25мг/2,5мл	ам	5
2	Суксаметазон	100мг/2 мл	ам	5
4. Хэсгийн мэдээгүйжүүлэх бэлдмэл				
1	Лидокайн	2%-2мл	ам	10
2	Новокайн	0,25%-100мл	фл	2
5.Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих				
1	Эпинефрин	0,1%-1мл	ам	20
2	Допамин	0,5%-5мл	ам	5
3	Норадреналин	16мг/8 мл	ам	10
4	Добутамин	250 мг/5 мл	ам	5
5	Амиодарон	150мг/3мл	ам	10
6	Атропин сульфат	0,1%-1мл	ам	5
7	Панангин	10мл	ам	5
8	Карведилол	6.25мг,	шах	10
9	Лансорбид	5мг, 10мг	шах	10
10	Атенолол	50мг	шах	10
11	Бисопролол	5мг, 10мг	шах	10

12	Нитроглицерин	0,5мг	фл	1
6.Цусны даралт бууруулах				
1	Эналаприл	1,25мг/1мл	ам	10
2	Никардипин	1мг/10 мл	ам	5
3	Эналаприл	5мг/10мг	шах	10
4	Амлодипин	5мг/10мг	шах	10
5	Нифедипин	10мг/20мг	шах	10
6	Экватор	5/10мг 10/20мг	шах	10
7	Лозартан+гипотиазид	100/25	шах	10
8	Валсартан	160мг	шах	10
7.Гуурсан хоолойн агчлын үедхэрэглэх				
1	Аминофиллин	2,4мг/ам-10мл	ам	5
2	Магнийн сульфат	25%-10мл	ам	6
3	Сальбутамол		фл	1
8.Харшлын ба анафилаксийн эсрэг				
1	Преднизолон	30мг-1мл	ам	3
2	Дексаметазон	4мг/1мл	ам	10
3	Дифенгидрамин /димедрол/	1%-1мл	ам	10
4	Кетотифен	1мг	Шах	10
9.Өвдөлт намдаах, халуун бууруулах				
1	Метамизол натри	50%-2мл	ам	10
2	Ревалгин	5мл	ам	5
3	Диклофенак натри	50мг-3мл	ам	10
4	Кетопрофен	100мг/2мл	ам	10
10.Цусны бүлэгнэлтэнд нөлөөлөх				
1	Аминокапроны хүчил	5%-100мл	фл	5
2	Транексамын хүчил	50мг/5мл	ам	10

3	Дицинон	125мг/2мл	ам	5
4	Фитоменадион	0,1%-1мл	ам	5
11.Цусны бүлэгнэлтийн эсрэг				
1	Гепарин	5000ед-1мл	фл	10
2	Ацетилсалицилийн хүчил	100мг	фл	1
3	Клопидогрел	75 мг	таб	10
12.Эрдэс зохицуулах				
1	Кальцийн хлорид	10%-10мл	ам	5
2	Калийн хлорид	7,5%-100мл	фл	2
13.Бөөр шээсний замд нөлөөлөх/ шээлгэх эм, тариа/				
1	Фуросемид	1%-2мл	ам	10
2	Спиринолактон	25мг	шах	10
3	Гидрохлортиазид	25мг	шах	10
14.Шингэнүүд				
1	Натрийн хлорид	0.9%-100мл	фл	10
2	Натрийн хлорид	0.9%-500мл	фл	10
3	Плазм -лит	1000мл	фл	5
4	Рингерийн уусмал	250мл	фл	5
5	Рингерийн уусмал	500мл	фл	5
6	Глюкоз	5%-500мл	фл	3
7	Глюкоз	40%-40мл	ам	10
8	Глюкоз	5%-250мл	фл	3
9	Глюкоз	5%-100мл	фл	3
10	Глюкоз	20%-100 мл	фл	3
11	Маннитол	10%-100мл	фл	5
12	Маннитол	10%-250мл	фл	5
15.Бөөлжилтийн эсрэг				

1	Метоклопрамид	0,5%-2мл	ам	10
2	Метоклопрамид	10мг	шах	10
16.Агчил тавиулах				
1	Дротаверин	2%-2мл	ам	10
17. Тархины цусан хангамж сайжруулах				
1	Цераксон	1000 мг	амп	5
2	Церебрализин	1 мл	амп	5
3	Актовегин	200 мг	амп	5
4	Нимодипин	50 мл	амп	3
18.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тариа				
1	Морфин гидрохлорид	10мг/мл-1мл	ам	5
2	Диазепам	10мг-2мл	ам	10
3	Трамадол	50мг/1мл	ам	5
4	Диазепам	5мг	шах	10
5	Фентанил	0.0005%-2мл	ам	30
6	Дроперидол	5мг/мл-2мл	ам	2
7	Кетамин	500мг/10 мл	фл	2
8	Мидозолам	5 мл	фл	2
19.Нэг удаагийн хэрэгсэл				
1	Эмнэлгийн вазелин	20гр	тюб	1
2	Уян бинт /өргөн, нарийн/		ш	12
3	Бинт		ш	5
4	Чангалуур		ш	2
5	Катетр		ш	10
6	Шээсний уут		ш	10
7	Шээсний сав		ш	10
8	Дуслын систем		ш	25

9	Нугасны хатгалтын зүү /22G, 20G/	Нэг удаагийн	ш	5
10	Тариур	1гр	ш	5
11	Тариур	3гр	ш	10
12	Тариур	5гр	ш	10
13	Тариур	10гр	ш	10
14	Тариур	20гр	ш	10
15	Уян зүү	18G	ш	10
16	Уян зүү	20G	ш	10
17	Уян зүү	22G	ш	10
18	Уян зүү	24G	ш	10
19	Хоосон вакумтеннер /зүүтэй/	Нэг удаагийн	ш	100
20	Мэс заслын утас №3,0 гурвалжин зүү	Нэг удаагийн	ш	12
21	Мэс заслын хутганы ир /8,10,12/	Нэг удаагийн	ш	30
22	Мэс заслын бээлий	Нэг удаагийн	ш	30
23	Ходоодны зонд №-18,16	Нэг удаагийн	ш	10
24	Электрод	Нэг удаагийн	ш	10
25	Бээлий	Нэг удаагийн	ш	100
26	Хүчилтөрөгчийн маск	Нэг удаагийн	ш	10
27	Хүчилтөрөгчийн хамрын гуурс	Нэг удаагийн	ш	10
28	Тамедин 7,5%	Нэг удаагийн	ш	3
29	Хлоргексидин уусмал -0,05%-100,0	Нэг удаагийн	ш	3
30	Төв венийн гуурс	Нэг удаагийн	ш	4
31	Малгай	Нэг удаагийн	Ш	20
32	Маск	Нэг удаагийн	Ш	20
33	N95 маск	Нэг удаагийн	Ш	10
34	Халад	Нэг удаагийн	ш	20

13.2 Амилуулах суурь тусламжинд нэн шаардлагатай эм, тарианы хэрэгслийн жагсаалт

13.3 шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт

1	Амбу	Н/хүрэгчид		ш	1
2	Амбуны маск	Н/хүрэгчид		ш	2
3	ларингоскопи	гар		ш	1
		хошуу	ТОМ		1
			жижиг		1
4	ЦМХ-н гуурс 8,0 7,5 7,0 6,5 6,0		ш	Т/б 1ш	
5	Чиглүүлэгч		ш	1	
6	Амаар агаар оруулагч		ш	1	
7	Соруулгын гуурс		ш	1	
8	Соруулгын хошуу		ш	10	
9	Хамрын салаа гуурс		ш	5	
10	Хүчилтөрөгчийн маск		ш	5	
11	Бэхлэгч		ш	5	
12	Электрод		ш	10	
13	Адерналин 0.1%-1мл		ам	5	
14	Атропин сульфат 0.1%-1мл		ам	3	
15	Амиодарон 5%-3мл		ам	1	
16	Допамин 4%-5мл		ам	1	
17	Лидокаин 2,0		ам	5	
18	Глюкоз 40%-10,0		ам	2	
19	Магнисульфат 25%-10,0		ам	2	
20	Пропофол 200мг/20мл		фл	1	
21	Тиопениталнатри 1000мг		фл	1	
22	Кетамин 500мг		фл	1	
23	Натрихлорид 0,9%-500мл		фл	2	
24	Натрихлорид 0,9%-250		фл	3	
25	Рингер лактат 250,0		фл	1	
26	Глюкоз 5%-250,0		Фл	1	
27	Манитол 10%-100,0		Фл	2	
28	Систем		ш	2	
29	Шприц 20гр		ш	3	
30	Шприц 10гр		ш	3	
31	Шприц 5,0 гр		ш	3	
32	Шприц 3,0 гр		ш	3	
33	Уян зүү 18G, 20G, 24G		ш	Т/б1ш	
34	Наалт		ш	1	
35	Ариун бээлий		ш	2	

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Байх ёстой тоо ширхэг
1.	Ор	1
2.	Амьсгалын аппарат	1
4	Монитор	1
5	Дуслын памп	1
6	Шахуургын памп	1
7	Ханын нэгдсэн систем / хүчилтөрөгч, соруулга/	1
8	Штатив	1
10	Яаралтай тэргэнцэр	1
11	Сувилагчийн тэргэнцэр	1
12	Дефибрилятор	1
14	Зүрхний бичлэг хийх аппарат	1
15	Даралтны аппарат	1
16	Биеийн дулаан хэмжигч	1
17	Чагнуур	1
18	Пульсоксиметр	1
19	Цусны глюкоз хэмжигч	1

14. ХАРИУЦЛАГА. Энэхүү журмыг зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд БОЭТөвийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.